



ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
“БОР-ӨНДӨР” БАГА СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 5/67

Бор-Өндөр

У.Ундралыг бага ангийн багшаар
түр томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1.4, 101 дүгээр зүйлийн 101.1, 145 дугаар зүйлийн 145.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага ангийн багш Д.Цовоод жирэмсэн болон амаржсаны амралт олгосон тул түүнийг амралттай байх хугацаанд Уртнасангийн Ундралыг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн бага ангийн багшийн албан тушаалд түр томилсугай.
2. У.Ундралын албан тушаалын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэл 1.273.000 (нэг сая хоёр зуун далан гурван мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.
3. Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг бага ангийн багш (У.Ундрал)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ